

**ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 01 дүгээр сарын 25

№01

Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн (1-203) өрөөнд 10:00 цагаас 95,7 хувийн ирцтэй явагдав.

Хуралд: дарга Н.Эрдэнэхүү, нарийн бичгийн дарга М.Эрдэнэтуяа, гишүүн Д.Оюунцэцэг, М.Оюунчимэг, Б.Оюунтунгалаг, Л.Амартүвшин, Г.Өлзийсайхан, А.Болормаа, Я.Батцэцэг, Ш.Цоож, П.Ууганбаяр, Г.Батцэцэг, Г.Мөнхсайхан, Д.Ариунболор, Д.Дулмаа, Д.Цэрэндолгор, Б.Аюурзана, Б.Мөнхцэнгэл, М.Дэлгэрмаа, Ц.Энхтуул, Г.Ариунтөгс нар оролцов.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. “073107 Хот ба бүс нутгийн төлөвлөлт” бакалаврын хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (БАС)
 - БАС-ийн дэд профессор Э.Пүрэв-Эрдэнэ
2. “073107 Хот ба бүс нутгийн төлөвлөлт” докторын сургалт, судалгааны хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (БАС)
 - БАС-ийн дэд профессор Э.Пүрэв-Эрдэнэ, Им Дахе
3. “072402 Уул уурхайн геотехник” магистрын сургалт, судалгааны хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (ГУУС)
 - ГУУС-ийн дэд профессор П.Нарантуяа
4. “104102 Тээврийн үйлчилгээ” магистрын сургалт, судалгааны хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (МехТС)
 - МехТС-ийн Тээврийн салбарын эрхлэгч И.Базаррагчаа
5. “071606 Авионик” магистрын сургалт, судалгааны хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (МехТС)
 - МехТС-ийн Тээврийн салбарын эрхлэгч И.Базаррагчаа
6. “Харилцааны англи хэл” хичээлийн агуулгыг шинэчлэн, нэрийг өөрчлөх тухай (ГХС)
 - ГХС-ийн СЧА-ны дарга А.Болормаа
7. ШУТИС-д хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж буй өнөөгийн байдал, сургалтын үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт хэлэлцүүлгийн санал, цаашдын төлөвлөлт
 - СБХА-ны дарга М.Эрдэнэтуяа

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. БАС-д шинээр нээх “Хот ба бүс нутгийн төлөвлөлт” бакалаврын хөтөлбөрийг ХЕХ хорооны гишүүдийн санал, зөвлөмжийн дагуу сайжруулан, БМИҮЗ-д урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэхийг дэмжлээ. Тус хөтөлбөрийн боловсруулалтад санал, зөвлөмж гаргах шинжээчээр ХЕХ-ны гишүүн Л.Амартүвшинг томиллоо
2. БАС-д шинээр нээх “Хот ба бүс нутгийн төлөвлөлт” докторын хөтөлбөрийг (үндсэн болон хамтарсан) ХЕХ хорооны гишүүдийн санал, зөвлөмжийн дагуу сайжруулан, БМИҮЗ-д урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэхийг дэмжлээ. Тус хөтөлбөрийн боловсруулалтад санал, зөвлөмж гаргах шинжээчээр ХЕХ-ны гишүүн Б.Мөнхцэнгэлийг томиллоо.
3. ГУУС-д шинээр нээх “072402 Уул уурхайн геотехник” магистрын сургалт, судалгааны хөтөлбөрийг ХЕХ хорооны гишүүдийн санал, зөвлөмжийн дагуу сайжруулан, дараагийн шатны хурлаар хэлэлцүүлэхийг дэмжлээ. Тус хөтөлбөрийн боловсруулалтад санал, зөвлөмж гаргах шинжээчээр ХЕХ-ны гишүүн Д.Дулмааг томиллоо.
4. МехТС-д шинээр нээх “104102 Тээврийн үйлчилгээ” магистрын сургалт, судалгааны хөтөлбөр хэрэгжүүлэх тухай асуудлыг БАТС, БУХС, МехТС-ийн хөтөлбөрийн дэд хорооны хамтарсан хурлын шийдвэр, АТХА-ны дүгнэлтийг үндэслэн хөтөлбөрийн ерөнхий хороонд хэлэлцүүлэхээр буцаалаа.
5. МехТС-д шинээр нээх “071606 Авионик” магистрын сургалт, судалгааны хөтөлбөрийг ХЕХ хорооны гишүүдийн санал, зөвлөмжийн дагуу сайжруулан, БМИҮЗ-д урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэхийг дэмжлээ. Тус хөтөлбөрийн боловсруулалтад санал, зөвлөмж гаргах шинжээчээр ХЕХ-ны гишүүн Д.Цэрэндолгорыг томиллоо.
6. ГХС-ийн хариуцан хэрэгжүүлдэг “Харилцааны англи хэл” хичээлийн агуулгыг шинэчилж, хичээлийн нэр, код өөрчлөхийг дэмжлээ. UNIMIS-д холбогдох зохицуулалтыг СБХА, ГХС-тай хамтран шийдвэрлэх.
7. ШУТИС-д хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж буй өнөөгийн байдал, сургалтын үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт хэлэлцүүлгийн санал, цаашдын төлөвлөлт асуудлыг дараах байдлаар шийдвэрлэв
 - “Хамтарсан хөтөлбөрийн гадаад хэлний хичээлийн кредитийг олон улсын түвшин тогтоох шалгалтын тодорхой түвшинд харгалзуулан дүйцүүлэлт /тооцох/ хийх” 1 дүгээр шийдвэрлүүлэх асуудлыг Гадаад хэлний сургууль хариуцан хэлний чиглэл бүрээр дүйцүүлэх зарчим гаргах, хөтөлбөр хэрэгжүүлж буй нэгж хамтын ажиллагаатай сургуулийн хэлний шаардлага хангасан байх зарчмыг хөтөлбөрийн баримтад дэлгэрэнгүй төлөвлөх.
 - “Хамтарсан хөтөлбөрийн (эхний 2 жилийн) сургалтыг үндсэн хөтөлбөртэй ижил төлөвлөх, гадаад хэлний хичээлийг үндсэн сургалтын хөтөлбөрийн нийт багц цагаас тусад нь хэлний бэлтгэл хэлбэрээр төлөвлөх” 2, 3 дугаар шийдвэрлүүлэх асуудалд СБХА нэгдсэн нэг загвар боловсруулах.